

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.11.10

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Төлбөрийн тэнцэл эхний 9 сарын байдлаар 53.2 сая ам.долларын ашигтай гарлаа.
- Монгол банк 10-р сард 2.8 тонн үнэт металл худалдан авлаа.
- “Премиум Нэксус” ХК хувьцаагаа 350 төгрөгөөр буцаан худалдан авах санал гаргалаа

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-1.32%	0.92%	25.47%
MSE A	-1.39%	-0.01%	20.27%
MSE B	-0.57%	-0.97%	34.89%

2025/11/03 – 2025/11/07

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Тоо ширхэг
AMT	1,662,922.00
MSE	691,104.00
KHAN	629,486.00
CUMN	565,575.00
XAC	560,226.00

2025/11/03 – 2025/11/07

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
HSX	8,500.00	16.06%
HSG	27,600.00	15.00%
AOI	2,500.00	14.63%
JTB	46.00	9.52%
CUMN	231.09	7.59%

2025/11/03 – 2025/11/07

2025 он 11-р сарын 10

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

12,911

ТОП-20 индекс

49,125

MSE A

19,087

MSE B

14,269



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - III улирал

Инфляц

9.0%

2025-09 сар

ГВУН(сая\$)

5,911.03

2025-10 сар

Бодлогын
хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.6%

USD/MNT

3,579.04


2025-11-09

Эдийн засгийн мэдээлэл

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ 2025 ОНЫ ЭХНИЙ 9 САРД 53.2 САЯ АМ.ДОЛЛАРЫН АШИГТАЙ ГАРЛАА

2025 оны эхний есөн сарын байдлаар төлбөрийн тэнцлийн урсгал данс 1.6 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 128.4 сая ам.доллараар (7.6%) буурсан үзүүлэлт болов. Урсгал дансны алдагдал буурахад голлон нөлөөлсөн хүчин зүйл нь үйлчилгээний худалдааны алдагдал 239.4 сая ам.доллараар (10.4%), мөн анхдагч орлогын дансны алдагдал 334.1 сая ам.доллараар (15.3%) тус тус багассантай холбоотой.

Нөгөө талаас, барааны худалдааны тэнцэл 2.0 тэрбум ам.долларын ашигтай гарсан ч өмнөх оны мөн үеэс ашиг 376.2 сая ам.доллараар (15.9%) буурсан байна.



2025 оны эхний есөн сард үйлчилгээний худалдааны орлого 1.5 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 309.1 сая ам.доллараар (25.2%) өссөн байна. Үйлчилгээний орлого нэмэгдэхэд тээврийн үйлчилгээний орлого 156.4 сая ам.доллараар (37.3%), аяллын орлого 83.1 сая ам.доллараар (15.5%), бусад үйлчилгээний орлого 69.7 сая ам.доллараар (25.9%) өссөн нь голлон нөлөөлжээ.

Үйлчилгээний нийт орлогын бүтэц нь дараах байдлаар бүрдсэн байна: 40.4% нь аялал жуулчлалын үйлчилгээ, 37.5% нь тээврийн үйлчилгээ, 22.1% нь бусад төрлийн үйлчилгээний орлого эзэлж байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МОНГОЛ БАНК 10-Р САРД 2.8 ТОНН ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА

2025 оны 10 дугаар сард Монголбанк 2,829 кг, оны эхнээс тооцсон нийт дүнгээр 12.7 тонн үнэт металл худалдан авсан байна. Үүнээс Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 722.6 кг, Баянхонгор аймгийн хэлтэс 1,532.9 кг үнэт металл авчээ. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар буурсан байна.

Монголбанк үнэт металлын худалдан авах үнийг дэлхийн зах зээлийн ханштай уялдуулан тогтоодог бөгөөд 2025 оны 10 дугаар сард алт худалдан авах дундаж үнэ 466,946.14 төгрөг байжээ.



Зах зээлийн мэдээлэл

ТОП-20 БА ПРЕИУМ НЭКСУС ХК (MSE:CUMN) ҮНЭЛГЭЭ

График 1. ТОП-20 ба CUMN үнэлгээний харьцуулалт





График 2. ТОП-20 ба CUMN үнэлгээнд үндэслэсэн ханш



CUMN хувьцааны үнэлгээний үзүүлэлтийг ТОП-20 индексийн үнэлгээтэй харьцуулж үзэн ханшийн таамаглалыг тооцож үзвэл хамгийн багадаа 245₮, хамгийн ихдээ 357₮-т хүрэх боломжтой гэж таамаглаж байна. Мөн P/E харьцаа дунджаас доогуур байна.


“ПРЕИУМ НЭКСУС” ХК ХУВЬЦААГАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ САНАЛ ГАРГАЛАА

Премиум Нэксус ХК-ийн 2025 оны 11-р сарын 07-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас хувьцаа эргүүлэн худалдан авах шаардах эрх хэрэгжүүлэх шийдвэр гарсан тул ТУЗ-ийн 2025 оны 11-р сарын 07-ны өдрийн №40 тоот тогтоолоор Компанийн тухай хуулийн 53.2, 54.3, 54.4, 54.5-д заасныг үндэслэн бусад хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, “Премиум Нэксус” ХК-ийн хувьцаа эзэмшигч “Премиум Коммерс” ХХК-д хувьцаа худалдан авах зөвшөөрөл олгосон байна. Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах шаардлагын тухайд

Хувьцаа худалдаж авах нэгж хувьцааны үнэ:	350 (гурван зуун тавин төгрөг)
Шаардах эрх үүссэн өдөр:	2025 оны 11-р сарын 07-ны өдөр
Хувьцаагаа эргүүлэн худалдах хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийг хүлээн авах хугацаа	2025 оны 11-р сарын 10-ны өдрөөс 2025 оны 12-р сарын 23-ний өдрийг дуустал
Эргүүлэн худалдах хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчдийн хувьцааны мөнгөн дүнг байршуулах хугацаа:	2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс 2026 оны 01 дугаар сарын 09-ний өдрийг дуустал

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

ВАЛЮТЫН ХАНШИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хэрэв нүүрсний үнэ 10%-иар буурч экспортын орлого 800 сая ам.доллараар багасна гэж үзвэл: 2026 онд инфляц 0.7 нэгж хувиар нэмэгдэхтэй уялдан төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3-5% орчим сулрах магадлалтай.

График 1. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш

